

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН 2017
ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

АУДИТЫН ТАЙЛАН , МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Аудитын код: ЗАА-2018/2/СТА-ОНТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: 0

Тэргүүлэх аудитор: Л.Уламбаяр

Утас: 70463612, 99058189 Цахим хаяг: zavkhan@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Хашцэцэг

Утас: 70462813, 99019467, 98323586 Цахим хаяг: Khash_aud@yahoo.com


Ахлах аудитор: Ч.Бямбасүрэн

Утас: Цахим хаяг:

Агуулга

| | | |
|-------|---|-------------------------------------|
| 1 | Аудитын гэрчилгээ | 2 |
| 2 | Аудитын тайлан | 3 |
| 2.1 | Оршил | 3 |
| 2.2 | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 3 |
| 2.3 | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 4 |
| 2.4 | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 4 |
| 2.5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 5 |
| 2.6 | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 5 |
| 2.7 | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 6 |
| 2.8 | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 6 |
| 2.9 | Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл | 7 |
| 2.9.1 | Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал | 7 |
| 2.9.2 | Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал | 7 |
| 2.9.3 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал | 7 |
| 2.9.4 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал | 8 |
| 2.10 | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 8 |
| 2.11 | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 8 |
| 2.12 | Шилэн дансны мэдээлэл | 9 |
| 2.13 | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 9 |
| 2.14 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 9 |
| 3 | Менежментийн захидал | 11 |
| 3.1 | «management_zurchil1» | Error! Bookmark not defined. |
| 3.2 | «management_zurchil2» | Error! Bookmark not defined. |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл | 15 |
| 4.1 | Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 15 |
| 4.2 | Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 15 |
| 4.3 | Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .. | Error! Bookmark not defined. |
| 4.4 | Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 15 |
| 4.5 | Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 15 |

1 Аудитын гэрчилгээ



**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
81000 Улаанбаатар, Завхан аймгаг
Утас/Факс: 7045-36-12

АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА
Л.ЛХАМСҮРЭН ТАНАА

2018.02.23 № 180

талай _____ -ны № _____ т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 16 дугаар зүйлийн 16.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 –д заасны дагуу Аймгийн ЗДТГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусааг болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Аймгийн ЗДТГ-ын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/эмчийн оорчлолт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын Баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэл, бодлоой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эргээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Аймгийн ЗДТГ-ын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйцээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэг хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгах, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохиистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санаг, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.


Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэх, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР





П.УЛАМБАЯР

STB-2017

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Аудитын тайлан, менежментийн захидлыг АЗДТГ-ын дарга, төсвийн шууд захирагч Л.Лхамсүрэнд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор *Аймгийн Засаг даргын тамгын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.*

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг *2018 оны 02 сарын 28* - наас *2018 оны 03 сарын 02* – ны хооронд хийж, аудитын тайланг *2018 оны 03 сарын 02* - нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн

удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Завхан аймаг дахь төрийн аудитын газрын Ахлах аудитор Ч. Бямбасүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2018 оны 01 сарын 22 - нд төрийн аудитын байгууллагад 2018 оны 01 сарын 19-ны өдрийн 3/96–р албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид Аудитын олон стандартад зааснаар үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Аймгийн Засаг даргын тамгын газар “Иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай хүргэх” эрхэм зорилгын дор үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Тайлант хугацаанд *Аймгийн Засаг даргын тамгын газар “Аймгийн хэмжээгээр төрийн албан хаагчийн сахилга хариуцлагыг сайжруулах”* дэвшүүлэн ажиллажээ.

Аймгийн Засаг даргын тамгын газар-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Аймгийн Засаг даргын тамгын газрын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
-

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Хүний нөөцийн стратеги төлөвлөлтийг шинэчлэн батлах төлөвлөгөө боловсруулсан. Хөгжлийн бодлогын төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн Аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулан мөрдөж эхэлсэн.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байна.

Тайлант онд санхүүгийн тайлан баталгаажуулалтын аудитаас гадна Монгол Улсын ЗГХЭГ-аас шалгалт хийгдэж, Төрийн албаны тухай хууль, Төрийн албаны зөвлөлөөс баталсан холбогдох заавар, журмыг зөрчиж албан тушаалд томилж, чөлөөлөгдсөн, Төсвийн тухай хуулийг зөрчиж тэтгэлэг, тусламж, хөнгөлөлт олгосон, төсвийн зарцуулалт, худалдан авах ажиллагаа, орон нутгийн өмчийн бүртгэл, тооцоотой холбоотой зөрчил, дутагдал илрүүлж 6 санал зөвлөмж өгсөн байна. Дээрх санал зөвлөмжүүдээс Аймгийн засаг даргын тамгын газрын үйл ажиллагаатай холбоотой зөвлөмж, саналуудыг арилган ажилласан байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын тамгын газар санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Acoulous4.0” програм хангамж ашиглажээ.

Ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн програм хангамж нь НББ-ийн стандарт шаардлагад нийцсэн байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аймгийн Засаг даргын тамгын газрын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй

нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 8 асуудал эрсдэл өндөр, 1 асуудал эрсдэл дунд, 2 асуудал эрсдэл бага гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 27 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 8 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь албан хаагчдын хурлаар материаллаг байдлын суурийг үр дүнгийн орлогоор тооцохоор тогтов.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2017 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 3388,0 сая төгрөг бөгөөд түүний 1 хувь 33,4 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 1 хувиар тооцсон нь төсөвт байгууллагатай холбоотой юм.

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 5 чиглэлээр 11 эрсдэлтэй асуудалд 11 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэн тэдгээрийн гол үр дүн, нөхцөл байдлыг үнэлэхэд хэрэгжүүлсэн нийт горим сорилын 33 хувь буюу 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-В-4.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

| № | Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал | Тоо | Дүн | Тайлбар |
|---|--|-----|------|---------|
| 1 | Зөвлөмж болгосон асуудал | 3 | 23.3 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 0 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0 | |
| | Дүн | 3 | 23.3 | |

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, ГАРГАСАН ШИЙДЭЛ

Аудитаар нийт 23,3 сая төгрөгийн 3 алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгөхөөр шийдвэрлэж байна.

Зөвлөмж болгохоор шийдвэрлэсэн буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 3 дугаар бүлгийн Менежементийн захидалд холбогдох зөвлөмжийн хамт оруулав.

Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал байхгүй

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй

2.9.4 Хууль хяналты байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

байхгүй

2.10 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ байхгүй

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Аймгийн Засаг даргын тамгын газар өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 2603,8 хөрөнгийн зардалд 192,0 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|-----|--|------------|-----------|------|-------|
| 1 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 2603,8 | 2603,8 | 0.0% | 0.0 |
| 1.1 | Урсгал зардал | 2603,8 | 2603,8 | 0.0% | 0.0 |
| 1.2 | Хөрөнгийн зардал | 192,0 | 192,0 | 0.0% | 0.0 |
| 1.3 | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | 0 | 0 | 0.0% | 0.0 |
| 2 | Зардлыг сахуужүүлэх эх үүсвэр | | | | |
| 2.1 | Улсын төсвөөс санхүүжих | | | | |
| 2.2 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | | | |
| 2.3 | Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос | | | | |

Төсөвт зардлын гүйцэтгэл (100) хувь байгаа нь хэтрэлт хэмнэлт байхгүй холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт (168) хувь байгаа нь түрээсийн орлого 11,3 сая төгрөгөөр давсантай холбоотой байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 272,2 сая төгрөг зарцуулсны дотор урсгал зардалд 272,2 төгрөг хөрөнгийн зардалд 0 төгрөг байна.

Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төсвийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Аймгийн Засаг даргын тамгын газар Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 11 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 11 горим сорил хэрэгжүүлэв.

Горим сорил хэрэгжүүлсний дүнд алдаа, зөрчилтэй асуудал байхгүй, төсөвт байгууллагын ил тод байдлын мэдээллийг бүрэн хангаж ажиллажээ.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2017 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийг *Аймгийн Засаг даргын тамгын газар* 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 1/96 дугаар албан бичгээр манайд ирүүлсэн бөгөөд аудитын явцад шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр биелэлтийн талаарх мэдээллийг дахин нягталсан болно.

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид *Аймгийн Засаг даргын тамгын газрын* 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа,

зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь *Аймгийн Засаг даргын тамгын газрын* нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

3.1 Удирдлагын түвшний асуудал

Илрүүлэлт

-Тайланд онд өмнөх аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан бөгөөд алдаа зөрчилтэй асуудал харьцангуй бага, анхан шатны баримтын бүрдэл болон НББ хөтлөлт холбогдох дүрэм, журам, стандартад бүрэн нийцсэн ахицтай үзүүлэлт байгаа боловч, дараах дутагдлууд илэрлээ. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн шийдвэргүйгээр Нэмэлт санхүүжилтийн дансанд Аймгийн төрийн сангаас ХО-ын техник хяналтын зардлаас 17,7 сая төгрөг хүлээн авч, автомашины урсгал засварын зардалд 17,0 сая төгрөгийг шатахууны зардалд 0,7 сая төгрөгийг тус тус зарцуулан Төсвийн тухай хуулийн 6.6.2/төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх;/ гэсэн заалтыг зөрчиж байна.

-Шагнал, урамшуулалыг хавтгайруулан олгосон, ажилласан жил цөөн, цаашид ажиллах тогтвор суурьшилгүй албан хаагчдад тэтгэмж олгож, төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан дутагдал нийтлэг байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1/төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;/ гэсэн заалттай нийцэхгүй байна.

-Сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн улс төрийн албан хаагчдын тэтгэмжийн зардлыг тус байгууллагын дансаар дамжуулан олгосон бөгөөд уг тэтгэмжээс ажлаас үндэслэлгүйгээр халагдаж шүүхийн шийтгэвэр гүйцэтгэлээр тэтгэмж олгогдож байгаа төрийн захиргааны албан хаагчид 1600,0 мянган төгрөгийг олгож төсвийг зориулалт бусаар

Зөвлөмж

- Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, хэмнэлттэй, үр ашигтай зарцуулах.
- Шийдвэргүйгээр нэмэлт санхүүжилтээр орон нутгийн сан болон нөөц хөрөнгө, ХО-ын техник хяналтын төвлөрсөн орлогуудаас санхүүжилт авч урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхгүй байх.
- Шагнал, урамшуулал, тэтгэмжийг төрийн албан хаагчийн шалгуур үзүүлэлтийг бүрэн хангаж байгаа албан хаагчдад олгож, нотлон баримтыг бүрэн бүрдүүлж хэвших.

| | |
|---|--|
| <p>зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн / дугаар зүйлийн 16.5.5 /батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;/</p> <p><u>Хариуцах ажилтан</u></p> <p>Төсвийн шууд захирагч Лхамсүрэн Нягтлан бодогч Г.Налжирмаа</p> | |
| <p><u>Эрсдэл</u></p> <p>-Төсөв хэтрэх, үрэлгэн зарцуулагдах -НББ-ийн хууль хэрэгжихгүй байх</p> | <p><u>Төсвийн захирагчийн хариу</u></p> <p>- Зөвшөөрсөн</p> |
| <p>3.2 АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ</p> | |
| <p><u>Илрүүлэлт</u></p> <p>- Засаг даргын орлогч дарга нарт удирдамж болон дуудсан бичиг, ажлын гүйцэтгэлгүйгээр 4060,0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон НББ-ийн тухай хуулийн 13.7 /Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно/, Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 7.3 дахь заалтуудыг зөрчиж байна.</p> <p><u>Хариуцах ажилтан</u></p> <p>Төсвийн шууд захирагч Лхамсүрэн Нягтлан бодогч Г.Налжирмаа</p> | <p><u>Зөвлөмж</u></p> <p>- Албан томилолтын зардлыг ажлын удирдамж, дуудсан бичиг, ажлын гүйцэтгэл, тайланг үндэслэн олгож хэвших</p> <p>- Зөвлөмжийн биелэлтийн хариуг 2018 оны 09 сарын 30-ны дотор ирүүлэх</p> |
| <p><u>Эрсдэл</u></p> <p>-Төсөв хэтрэх, үрэлгэн зарцуулагдах -НББ-ийн хууль хэрэгжихгүй байх</p> | <p><u>Төсвийн захирагчийн хариу</u></p> <p>- Зөвшөөрсөн</p> |

Тайлан бичсэн: Аудитор

Ч. Бямбасүрэн

Анхан шатанд хянасан: Аудитын менежер

Г.Хашцэцэг

Хоёр дахь шатанд хянасан: Тэргүүлэх аудитор

Л.Уламбаяр

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан